



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК



ГАДААД ШИЛЖҮҮЛЭГ
ХИЙХ БОЛОН ЦАХИМ ГЭМТ
ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨМЖ



ГАДААД ШИЛЖҮҮЛЭГ ХИЙХ БОЛОН ЦАХИМ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖ

Банк нь харилцагчийнхаа гадаад гүйлгээг түргэн шуурхай дамжуулах, банкны бүтээгдэхүүн үйлчилгээгээ Олон улсын стандартад нийцүүлэн харилцагчид хүргэн ажиллахын зэрэгцээ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Олон улсын стандарт, зохицуулагч байгууллагууд болон корреспондент банкны шаардлагыг дагаж мөрдөх, биелүүлэх хүрээнд харилцагчийн зарим төлбөр тооцоонд тусгайлсан хяналт тавих, хяналтын хүрээнд харилцагчийг таньж мэдэх зорилгоор холбогдох баримт бичиг, мэдээ, мэдээллийг авч, баталгаажуулах үүрэгтэй байдаг билээ.

Дэлхий дахинд шинэ технологи үсрэнгүй хөгжиж, түүний хэрэглээний цар хүрээ нэмэгдэхийн хэрээр цахим орчинд хийгдэх залилан, хууль бус үйл ажиллагаа, гэмт хэргийн шинж чанартай үйлдэл их гарах болсон.

Тухайлбал, сүүлийн үед фишинг буюу интернэт залилан үйлдэх, гаднын улс, орноос харилцаа тогтоон луйвардах, гуравдагч этгээдийн дансаар цахим мөрийтэй тоглоомын гүйлгээ дамжуулах, залилах, мөнгө угаах зэргээр цахим сувгийг хууль бус үйлдэлд ашиглах хандлага нэмэгдсээр байна.

Иймд, банкны зүгээс харилцагчдаа учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх хүрээнд, Олон улсын сайн туршлага, удаан хугацааны ажиглалтын үр дүнд харилцагч таныг гэмт хэргийн хохирогч болохоос хамгаалах зорилгоор дараах зөвлөмжийг бэлтгэлээ. Харилцагч Та гадаад шилжүүлэг хийхийн өмнө дараах зөвлөмжтэй танилцаж, учирч болзошгүй болон гэмт хэргийн хохирогч болох эрсдэлээс өөрийгөө хамгаална уу.

ДЭЛХИЙ НИЙТЭД ҮҮСЭЖ БҮЙ ЭРСДЭЛҮҮД

Гадаад шилжүүлэг хүлээн авагчтай анх удаагаа санхүүгийн харилцаа үүсгэж, гадаад шилжүүлгийн гүйлгээ хийж буй тохиолдолд:

Зөвлөмж:

- Онлайнаар танилцсан, бодитоор уулзаж байгаагүй гаднын улс, орны иргэнд мөнгө шилжүүлэхгүй байхад онцгой анхаарах;
- Хүлээн авагчийн талаар албан ёсны эх сурвалжаас судлан, бодитоор үйл ажиллагаа явуулдаг эсэхийг нь баталгаажуулах;
- Аливаа мөнгөн хөрөнгө шилжүүлэхдээ байр орон сууц, машины худалдах, барьцаанд тавин найз нөхөд, ах дүүс гэр бүлийн хүмүүсээс мөнгө зээлэн шилжүүлэг хийхээс сэргийлэх;
- International Bank Account Number (IBAN)-ийг сайтар шалгах. Европын банкууд нь (IBAN) буюу Нэгдсэн дансны системийг нэвтрүүлсэн байдаг бөгөөд төлбөрийн даалгавар дахь хүлээн авагчийн нэртэй тулгаж шалгахгүйгээр, зөвхөн IBAN дугаарын дагуу төлбөрийг хүлээн авдаг. Иймд, IBAN дугаарыг буруу бичсэн тохиолдолд гадаад шилжүүлгийн гүйлгээ нь гуравдагч этгээдийн дансанд орох, гүйлгээг буцаан лавлах боломжгүй, эсхүл цаг хугацаа, хөрөнгө шаардагдах, цаашлаад мөнгөн хөрөнгийг алдах хүртэлх нөхцөл байдал үүсэж болзошгүйг анхаарах;
- Гадаад шилжүүлгийн оролцогч талууд болон гүйлгээнд хамаарах мэдээллүүдийг тусгасан, тамга тэмдгээр баталгаажсан, нэхэмжлэх, эсхүл холбогдох бусад баримтыг төлбөр хүлээн авагчаас авсан байх.

Та хүлээн авагчаа баталгаажуулаагүй мөн хүлээн авагчаас төлбөр хүлээн авах банк болон дансны дугаар өөрчлөгдсөн талаар цахим сувгаар эсхүл зайнаас мэдэгдэж, Та тухайн өгсөн шинэ мэдээллийн дагуу гүйлгээ хийх гэж буй тохиолдолд:

Зөвлөмж:

Төлбөр шилжүүлэгчийн харилцаж буй гадаадын хуулийн этгээдийн цахим шууданг хакердаж, бизнесийн түншүүдэд нь банк болон дансны дугаараа өөрчилсөн талаар мэдэгдэж, өөрсдийн дансны дугаараа өгч, улмаар тухайн дансаар бараа, ажил үйлчилгээний төлбөрийг хүлээн авдаг залилангийн төрөл байдаг. Энэ тохиолдолд таны бизнесийн хамтрагчид өөрийн цахим шуудангаа хакерт өртсөнийг мэдээгүй байх нь түгээмэл бөгөөд банк болон дансны дугаар өөрчилсөн талаарх мэдээлэл илгээсэн шуудангаас бусад шуудан, бизнесийн харилцаа нь хэвийн үргэлжилсээр байдаг. Иймд, хэрэв таны бизнесийн түнш банк болон дансныхаа мэдээллийг өөрчилсөн талаар мэдээлэл ирүүлбэл энэ талаар нь бусад найдвартай суваг, тухайлбал утсаар лавлаж, баталгаажуулах нь зүйтэй.

- Хүлээн авагчийн талаар албан ёсны эх сурвалжаас судлан бодитоор үйл ажиллагаа явуулдаг талаар баталгаажуулах;
- Мөнгөн хөрөнгө шилжүүлэхдээ зөвхөн баталгаажуулсан хүлээн авагчийн данс руу шилжүүлэх;
- Төлбөр хүлээн авагчаас гүйлгээнд оролцогч болон гүйлгээний мэдээллүүд тусгасан тамга тэмдгээр баталгаажсан нэхэмжлэх шаардан авах;
- Дансны мэдээлэл нь өөрчлөгдсөн талаар мэдээллийг и-мэйлээр хүлээн авбал заавал утсаар холбогдож баталгаажуулж байх.

Гуравдагч этгээд нь өөрийн нэр, мэдээлэл болон үйлдлийг нуун далдлах зорилгоор өөр харилцагчийн дансыг далдаар удирдах, түүгээр дамжуулан гүйлгээ хийхийн тулд харилцагчид шан харамж амлаж улмаар банканд бүртгэл үүсгүүлэн харилцагчийн интернэт банкны мэдээллийг авах тохиолдолд:

Зөвлөмж:

- Бусдын ятгалгаар гуравдагч этгээдэд нууц мэдээллээ дамжуулах, ашиглуулахгүй байх;
- Гуравдагч этгээд таны дансыг захиран зарцуулсан тохиолдолд та эцсийн хариуцлагыг хүлээж, аливаа гүйлгээний харьцсан дансны мэдээлэлд таны мэдээлэл гарч ирэхийг санан, ийм төрлийн хүсэлтийг хүлээж авахгүй байх.

Харилцагчийн хувийн мэдээллийг хакердан, залилан хууль бус гүйлгээ хийх:

Зөвлөмж:

- Банкин дах хувийн мэдээллээ бусдад алдахаас сэргийлж, тодорхой хугацааны давтамжтайгаар шинэчлэн, аюулгүй байдлыг хангах;
- Цахим банкны нэвтрэх нэр, нууц үг болон нэг удаагийн нууц үгийг ямар ч тохиолдолд бусдад дамжуулахгүй байх, сэжигтэй санагдсан тохиолдолд бүрд сольж хэвших;
- Хэрэв таны дансаар сэжигтэй гүйлгээ дамжих эсвэл тийм оролдлого ажиглагдвал салбар нэгжид яаралтай хандаж, энэ талаар мэдэгдэх.

Интернэт зар, койн, зохиомол үнэ, хуурамч төсөл, санхүүгийн тусламж, зээлийн үйлчилгээ, худалдаа, арилжаа наймааны саналын дагуу мөнгөн хөрөнгө урьдчилан шилжүүлэх тохиолдолд:

Зөвлөмж:

- Хөрөнгө оруулалт, крипто арилжаа хийх тохиолдолд хөрөнгө оруулалт хийх төсөл койны талаар баталгаат эх сурвалжаас судлах;
- Бусдын ятгалаг, сүрдүүлгэн дор болон санхүүгийн тооцоогүйгээр зээл авч, хөрөнгө оруулалт хийхээс зайлсхийх;
- Олон нийтийн сүлжээгээр “Гадаад валют хямд ханшаар солино”, “Хямд үнээр бараа зарна”, “Зээл олгоно” гэх мэт зар тавьж, хүмүүсийн анхаарлыг татах, уг бараа үйлчилгээг авахын өмнө урьдчилгаа төлбөр, түүнд холбогдох шимтгэлийг шилжүүлэх нөхцөл тавьж байгаа тохиолдолд эдгээр нь залилан мэхлэх үйлдэл байх өндөр магадлалтай байдгийг санана уу. Ийм төрлийн залилан хийж буй иргэд хууль хяналтын байгууллагаас зугтахын тулд гадаад улсад ихэвчлэн амьдардаг хэдий ч дотоодын арилжааны банкны дансыг ашиглан мөнгө хүлээн авдаг хэв шинж бүхий байдаг. Харилцагч та энэ төрлийн хуурамч, үндэслэлгүй зарын мэдээлэлд автахгүй байж, өөрийн мөнгөн хөрөнгөө алдах эрсдэлээс сэргийлнэ үү.

Танд илгээсэн бэлэг сэлт, бараа эсхүл өв залгамжлал, бизнесийн хөрөнгө оруулалт хүлээн авахтай холбоотой төлбөр төлөх тохиолдолд:

Зөвлөмж:

- Романс залилан (Romance scam) буюу хайр дурлалын аргаар залилах гэмт хэрэг - Олон нийтийн сүлжээ, чат зэрэг цахим сувгаар удаан хугацаанд харилцаж, хохирогчийн итгэлийг олж авсны дараагаар “Бэлэг сэлт, сейфтэй бэлэн мөнгө, эсхүл үнэт эдлэл илгээсэн бөгөөд илгээмж нь аль нэг улсын гааль дээр саатсан тул холбогдох төлбөрийг шилжүүлэхийг хүсэх”, “Монгол Улсад очих тасалбар, зардал явуулахыг хүсэх” гэх мэт байдлаар мөнгө залилж авдаг олон улсын хэмжээнд “Романс залилан” гэж нэрлэгддэг залилан түгээмэл байдаг. Залилагчид мөнгөө хурдан авах зорилготой байдаг тул ихэвчлэн Мониграмм зэрэг мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ашиглах хандлагатай байдаг ба энэ төрлийн үйлчилгээнд хүлээн авагч байгууллага нь валют арилжааны цэг, ББСБ-ууд байдгаас улбаалан төлбөр буцаан лавлах боломж бараг байхгүй юм. Иймд, харилцагч Та романс залилангийн дээрх хэв шинж бүхий үйлдэл, харилцаанаас өөрийгөө хамгаалж, мөнгөн хөрөнгөө алдахаас сэргийлнэ үү.

- Хуурамч хөрөнгө оруулалтын залилан (Fake investment) - Иргэд, хуулийн этгээдээс бизнесийн төсөл, саналыг хүлээн авч, түүнд их хэмжээний хөрөнгө оруулалт хийнэ гэж итгүүлэн, хуулийн, нотариатын, үйлчилгээний гэх мэт шимтгэл, хураамж төлүүлэх нэрийдлээр мөнгө залилдаг арга олон улсад нийтлэг байдаг. Ийм төрлийн залилан хийж буй этгээдүүд ихэнхдээ өөрсдийгөө хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг гэж танилцуулдаг бөгөөд хэдэн саяас хэдэн тэрбум хүртэлх гадаад валютын хөрөнгө оруулалт хийнэ гэж амлаж, хохирогч талд бизнес хамтын ажиллагааны гэрээ, их хэмжээний мөнгийг илгээсэн гэх гүйлгээний хуурамч баримт үзүүлэх зэргээр итгэл төрүүлдэг. Мөн тэдгээр этгээдүүд өөрсдийн гэсэн хуурамч компани, тамга тэмдэг, веб сайттай байх нь түгээмэл байдаг. Иймд, харилцагч Та дээрх хэв шинж бүхий харилцааны нэг хэсэг болохоос сэргийлж, санхүүгийн байгууллагын нэр хүндэд халдах, мөнгөн хөрөнгө болон цаг хугацаа алдахаас үүсэх эрсдэлээс өөрийгөө хамгаална уу.
- Өв залгамжлалын залилан (Inheritance scam) - Гэр бүл, санхүүгийн байдал, нас хүйс үл харгалзан, гаднын улс орноос харилцаа тогтоон, "таны нэр нь нас барсан иргэний өв залгамжлалыг хүлээн авах боломжтой нэртэй таарч байна" гэсэн агуулгатай зурвас ирүүлж, улмаар илгээмж болон их хэмжээний мөнгө шилжүүлнэ гэж итгэл төрүүлэн, эхний ээлжинд хуулийн үйлчилгээ, нотариатын төлбөрийг шилжүүлэхийг ятгах төрлийн залилан түгээмэл байдаг. Энэ тохиолдолд залилагч этгээд мөнгөө хурдан авах зорилгоор мөн мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ашиглах хандлагатай байдаг. Энэ төрлийн луйврын үйл ажиллагаанд шилжүүлэг, гуйвуулгын үйлчилгээнд хүлээн авагч байгууллага нь валют арилжааны цэг, ББСБ-ууд байдгаас төлбөрийг буцаан дуудах боломж хомс тул Та энэ төрлийн эрсдэлд өртөхөөс сэргийлнэ үү.



ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ:

Утас: +976 1900-1977

Вэб хаяг: www.tdbm.mn

/// бахдал.эрдэнэс.мэдрэгч